



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2023 оны III улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	8
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	8
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгөн хөрөнгө.....	12
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	13
Факторингийн тооцооны авлага.....	13
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	14
Зээл.....	14
Цахим зээл	17
Ногоон зээл	19
Бусад хөрөнгө	20
Эргэлтийн бус хөрөнгө	20
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	21
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	22
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	22
Бусад эх үүсвэр	23
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	23
Төслийн зээлийн санхүүжилт.....	24
Бусад өр төлбөр	25
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	25
Бусад өмч, сангууд	26
Хуримтлагдсан ашиг	26
Хоёрдогч өглөг.....	27
Ашигт ажиллагаа	27
Гадаад валютын арилжааны мэдээ	28
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	29
Дүгнэлт	30
Актив, пассивын бүтэц.....	30
Ашигт ажиллагаа	30
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	31

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 5 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	9
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	9
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	12
Хүснэгт 16 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 17 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 18 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/	14
Хүснэгт 19 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	14
Хүснэгт 20 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	16
Хүснэгт 21 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	16
Хүснэгт 22 Зээлийн ангилал	17
Хүснэгт 23 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд /2023 оны III улирал/	17
Хүснэгт 24 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/	19
Хүснэгт 25 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/.....	20
Хүснэгт 26 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	20
Хүснэгт 27 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	21
Хүснэгт 28 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/.....	22
Хүснэгт 30 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/	23
Хүснэгт 31 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	23
Хүснэгт 33 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/.....	23
Хүснэгт 34 Өрийн бичиг /валютаар/.....	24
Хүснэгт 36 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	24
Хүснэгт 37 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/.....	25
Хүснэгт 38 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	25
Хүснэгт 39 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	26
Хүснэгт 40 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	26
Хүснэгт 41 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/.....	26
Хүснэгт 43 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/	27
Хүснэгт 44 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	28
Хүснэгт 45 Валютын арилжааны мэдээ улирал бүр /тэрбум төгрөгөөр/	28
Хүснэгт 47 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	29

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	13
Зураг 5 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	15
Зураг 6 Зээлийн багцын чанар /хувиар/.....	15
Зураг 7 Олгосон зээл /хугацааны ангиллаар/	16
Зураг 8 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/.....	19
Зураг 9 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	21
Зураг 10 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	22
Зураг 11 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	22
Зураг 12 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/	23
Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	24
Зураг 14 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	25
Зураг 15 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	27

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2023 оны III улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 521 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 ББСБ буюу 0.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 93 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 25 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2019-III	2020-III	2021-III	2022-III	2023-III
Шинээр олгосон	9	12	9	14	18
Хүчингүй	9	8	10	26	10
Түдгэлзүүлсэн	10	25	20	57	12
Сэргээсэн	8	4	6	19	17
Нийт ББСБ	539	533	531	522	521
Үүнээс: ХОН	74	77	80	91	93
Үүнээс: ГХО	28	29	29	26	25
Салбар	240	285	313	419	453
Төлөөлөгч	7	9	8	7	11

2023 оны III улирлын байдлаар 18 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 10 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 12 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 17 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2023 оны III улирлын байдлаар 45 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2022-III	2023-III	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	3,400.8	4,257.4	25.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	8.2%	8.6%	1.1%
Нийт өөрийн хөрөнгө	2,124.7	2,589.6	21.9%
Банкны салбартай харьцуулахад хувиар	53.4%	49.1%	0.3%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,275.5	1,453.0	13.9%
Банкны салбартай харьцуулахад хувиар	80.5%	87.5%	10.7%
Нийт зээл	2,666.1	3,378.5	26.7%
Банкны салбартай харьцуулахад хувиар	11.4%	12.8%	2.3%
Нийт орлого	624.8	814.7	30.4%
Нийт зарлага	389.8	512.3	31.4%
Цэвэр ашиг	235.0	302.4	28.7%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар өсөж, банкны салбарын 8.6%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 87.5%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.7 пунктээр өссөн дүн юм.

2023 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар буюу 856.6 тэрбум төгрөгөөр өсөж 4.3 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 83.2 хувийг нийт зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 54.3 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 30.4 хувиар буюу 189.9 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 31.4 хувиар буюу 122.5 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 28.7 хувиар буюу 67.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2022-III	2023-III	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	522	521	(1)	-0.2%
1	Зээл	484	479	(5)	-1.0%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	316	339	23	7.3%
2	Факторингийн үйлчилгээ	43	51	8	18.6%
3	Төлбөрийн баталгаа гаргах	28	28	-	0.0%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	6	1	20.0%
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	37	45	8	21.6%
6	Гадаад арилжаа валютын арилжаа	140	147	7	5.0%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	38	40	2	5.3%
7	Итгэлцлийн үйлчилгээ	61	82	21	34.4%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	22	26	4	18.2%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 521 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 91.9% нь буюу 479 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 65.1% нь буюу 339 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 147 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 28.2 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 39 ББСБ нийт ББСБ-уудын 7.5 хувийг бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл итгэлцлийн үйлчилгээ 34.4 хувиар, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 21.6 хувиар, факторингийн үйлчилгээ 18.6 хувиар тус тус өссөн байна. Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 669 дүгээр тогтоолоор нэр бүхий 39 ББСБ-ын хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр

зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосон ба 2023 оны III улирлын байдлаар 26 ББСБ тусгай зөвшөөрлөө хүчингүй болгосон тухай өөрчлөлтөө улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгүүлсэн байна.

2023 оны III улирлын тайлан мэдээний ирц 96.2% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 521 ББСБ-аас 501 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 20 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Өмнөх улирлын байдлаар нэгтгэлд хамрагдсан 20 ББСБ-аас 3 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлэх арга хэмжээг Хяналт шалгалт зохицуулалтын газраас авч хэрэгжүүлсэн байна.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

- [“Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”](#)-д Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамд 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/283 тоот албан бичгээр өөрчлөлтийг хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- 2023 оны III улиралд Цахим зөвлөлийн хуралдаанаар журмын шаардлага хангасан [34 ББСБ-ын 32 аппликэйшнийг Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд бүртгэсэн](#) байна. Финтек зээлийн үйлчилгээний эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор цахим зээл олгож байгаа ББСБ-уудыг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган бүртгүүлэх хугацаа өгсөн бол шинээр финтек зээлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ууд нь журмын шаардлагыг ханган, бүртгүүлэх хүсэлтээ ирүүлэх боломжтой. Журам батлагдсанаас хойш зөвшөөрөлгүй финтек зээлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ-уудад журамд заасан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 498 дугаар тушаалаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, зааврыг боловсруулах, судалгаа шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулсан бөгөөд СЗХ-ны 2023.03.13-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”, 82 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх,

тайлан мэдээ ирүүлэх журам”, 83 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох”, 84 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”, 85 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 6484-6488](#) тоот дугаарт бүртгүүллээ.

- Банкны тухай хуулийн 6.2-т заасны дагуу 2 банканд факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олголоо. [2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор](#) Хаан банканд, [2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 97 дугаар тогтоолоор](#) Худалдаа хөгжлийн банканд тус тус олгосон байна.

- Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 1,200,000,000 /нэг тэрбум хоёр зуун сая/ төгрөг, бусад аймаг, сумдад 400,000,000 /дөрвөн зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосон ба итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд 3 жил дараалан үе шаттай нэмэгдүүлэхээр тогтоосныг Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 6222 тоот дугаарт бүртгүүлсэн](#) байна.

- Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах түүнд хяналт тавих журамд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 220 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдөр холбогдох хөдөлгөөн хийгдэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн байна.](#)

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 434 дүгээр тогтоолоор Итгэлцлийн үйлчилгээний журмыг баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 6426 тоот дугаарт бүртгүүлсэн](#) байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2023 оны III улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 91.1 хувь буюу 461 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 84.8 хувь буюу 429 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 479 ББСБ бүгд Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ын аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 116 ББСБ, 3980 удаагийн тохиолдлоор, 1,294.2 сая төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 4 ББСБ, 32 удаагийн тохиолдлоор, 2,809.1 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2023 оны III улирлын байдлаар нийт 505 ББСБ-аас 1,254.7 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 94.0% буюу 471 ББСБ 1,179.3 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2023 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 28,369 хувьцаа эзэмшигчдийн 521 ББСБ, 453 салбар нэгж, 11 төлөөлөгчийн газар, 4,909 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 9 дүүрэгт давхардсан тоогоор 4.1 сая харилцагч, 1.5 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар буурч давхардсан тоогоор 4,141,367-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар буурч 1,461,398-д хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,141,367	3,550,235	263,211	3,878,156	58,412	4,113,097	28,270	342,303	98,981
Үүнээс: Эмэгтэй	2,257,077	1,934,127	133,066	2,124,011	31,889	2,240,627	16,450	188,857	53,016
Эрэгтэй	1,878,196	1,615,124	124,693	1,753,503	22,681	1,866,428	11,768	153,154	45,635
Хуулийн этгээд	6,088	978	5,446	642	3,842	6,036	52	292	330
Итгэмжлэгчдийн тоо	7,681	7,680	2,215	5,466	-	7,676	5	3,088	344
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,480	1,402	191	1,289	-	1,454	26	865	503
Зээлдэгчдийн тоо	1,461,198	931,626	200,175	1,261,023	-	1,433,807	27,391	193,213	98,977
Хэвийн	1,277,054	789,724	173,326	1,103,728	-	1,255,550	21,504	160,488	81,935
Хугацаа хэтэрсэн	43,872	33,468	7,437	36,435	-	42,171	1,701	7,866	3,072
Чанаргүй:	140,284	108,446	19,424	120,860	-	136,098	4,186	24,859	13,970
-Хэвийн бус	35,772	27,566	5,501	30,271	-	34,381	1,391	8,384	5,493
-Эргэлзээтэй	44,915	34,856	5,390	39,525	-	43,605	1,310	9,668	6,444
-Муу	59,597	46,024	8,533	51,064	-	58,112	1,485	6,807	2,033
Зээлдэгчдийн насжилт	1,459,331	930,717	198,893	1,260,438	-	1,431,990	27,341	192,910	98,647
18-35 насны	904,064	553,455	84,071	819,993	-	890,306	13,758	114,562	58,769
36-45 насны	355,943	240,064	65,339	290,604	-	347,617	8,326	50,069	24,520
46-55 насны	160,259	105,995	36,666	123,593	-	156,350	3,909	22,527	12,077
55-аас дээш	39,065	31,203	12,817	26,248	-	37,717	1,348	5,752	3,281
Зээлдэгчдийн боловсрол	1,459,331	930,717	198,893	1,260,438	-	1,431,990	27,341	192,910	98,647
-Дээд	799,011	578,608	112,749	686,262	-	785,345	13,666	114,485	64,918
-Тусгай дунд	126,135	64,590	18,738	107,397	-	123,097	3,038	18,772	13,361
-Бүрэн дунд	413,212	236,516	45,300	367,912	-	404,360	8,852	44,207	15,195
-Дунд	78,689	35,924	10,712	67,977	-	77,298	1,391	13,595	4,421
-Бага	42,284	15,079	11,394	30,890	-	41,890	394	1,851	752

/Финтек ББСБ-ууд финтек уламжлалт зээл хослуулан олгодог болно/

Нийт харилцагчдын 93.6% буюу 3,878,156 нь, зээлдэгчдийн 86.3% буюу 1,261,023 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 6.4% буюу 263,211 нь, зээлдэгчдийн 13.7% буюу 200,175 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 58,412 буюу нийт харилцагчдын 1.4 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2019-III	2020-III	2021-III	2022-III	2023-III	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	7,672	8,669	21,666	23,143	28,369	5,226	22.6%
Ажилчдын тоо	3,003	3,417	3,820	4,478	4,909	431	9.6%
Харилцагчдын тоо	1,575,389	2,639,297	4,530,126	4,897,575	4,141,367	(756,208)	-15.4%
Зээлдэгчдийн тоо	383,670	551,977	1,562,757	1,644,423	1,461,198	(183,225)	-11.1%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.10%	2.90%	2.60%	3.1%	3.3%	+0.2%	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар буюу 5,226-аар өсөж 28,369-д хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.3 хувь буюу 27,332 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,037 буюу 3.7% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 2,607 буюу 9.2% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа

эзэмшигчид байгаа бол 209 буюу 0.7% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	28,369	27,528	1,865	26,504	59	28,160	209	27,332	2,607
Нийт ажилтнуудын тоо	4,909	2,844	2,604	2,305	116	4,642	267	431	426
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,871	1,619	1,585	1,286	62	2,684	187	266	256
Эрэгтэй ажилтны тоо	2,038	1,225	1,019	1,019	54	1,958	80	165	170

Хөдөө орон нутгийн 93 ББСБ 6 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	521	82	476	45	40	428	93	5	516	25
1 Зээл	479	82	434	45	-	389	90	5	474	25
2 Факторингийн үйлчилгээ	51	26	33	18	-	51	-	3	48	3
3 Төлбөрийн баталгаа гаргах	28	16	21	7	-	27	1	2	26	5
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	5	-	6	-	6	-	1	5	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	45	21	29	16	-	43	2	3	42	1
6 Гадаад валютын арилжаа	147	34	130	17	40	136	11	4	143	6
7 Итгэлцлийн үйлчилгээ	82	82	58	24	-	79	3	5	77	7
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	26	18	18	8	-	24	2	2	24	3
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 82.1% буюу 428 ББСБ, салбаруудын 62.5% буюу 283 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 17.9% буюу 93 ББСБ, салбаруудын 37.5% буюу 170 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2023 оны III улирлын байдлаар 103 ББСБ-ын 453 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 62.9 хувийг 13 ББСБ-ын 280 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн 428	Салбар 283	Нийт 711	Хувь 100.0%
Сүхбаатар дүүрэг	140	41	181	25.5%
Чингэлтэй дүүрэг	120	41	161	22.6%
Баянзүрх дүүрэг	46	67	113	15.9%
Баянгол дүүрэг	71	40	111	15.6%
Хан-Уул дүүрэг	41	34	75	10.5%
Сонгинохайрхан дүүрэг	9	50	59	8.3%
Багануур дүүрэг	1	6	7	1.0%
Налайх дүүрэг	-	4	4	0.6%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, Өвөрхангай, Дархан-Уул аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн 93	Салбар 170	Нийт 263	Хувь 100%
Архангай аймаг	3	7	10	3.8%
Баян-Өлгий аймаг	3	4	7	2.7%
Баянхонгор аймаг	4	8	12	4.6%
Булган аймаг	2	2	4	1.5%
Говь-Алтай аймаг	1	2	3	1.1%
Говьсүмбэр аймаг	2	3	5	1.9%
Дархан-Уул аймаг	8	13	21	8.0%
Дорноговь аймаг	1	9	10	3.8%
Дорнод аймаг	5	14	19	7.2%
Дундговь аймаг	-	5	5	1.9%
Завхан аймаг	2	4	6	2.3%
Орхон аймаг	11	16	27	10.3%
Өвөрхангай аймаг	10	12	22	8.4%
Өмнөговь аймаг	2	14	16	6.1%
Сүхбаатар аймаг	5	7	12	4.6%
Сэлэнгэ аймаг	6	12	18	6.8%
Төв аймаг	17	6	23	8.7%
Увс аймаг	4	7	11	4.2%
Ховд аймаг	1	6	7	2.7%
Хөвсгөл аймаг	3	10	13	4.9%
Хэнтий аймаг	3	9	12	4.6%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2023 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 4.3 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.2 хувиар буюу 856.6 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 83.2 хувийг нийт зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2022-III дүн	Нийт дүнд эзлэх хувь	2023-III дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	3,294,186.2	96.9%	4,121,960.6	96.8%	827,774.4	25.1%
Мөнгөн хөрөнгө	401,993.4	11.8%	529,286.0	12.4%	127,292.5	31.7%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	15,957.6	0.5%	41,678.2	1.0%	25,720.6	161.2%
Зээл (цэврээр)	2,524,028.7	74.2%	3,189,615.7	74.9%	665,586.9	26.4%
Нийт зээл	2,666,130.1	78.4%	3,378,459.1	79.4%	712,329.0	26.7%
(Зээлийн эрсдэлийн сан)	142,101.3	4.2%	188,843.4	4.4%	46,742.1	32.9%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	10,355.5	0.3%	15,223.2	0.4%	4,867.7	47.0%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	19,666.2	0.6%	21,533.6	0.5%	1,867.4	9.5%
Бусад хөрөнгө	322,144.1	9.5%	319,434.7	7.5%	-2,709.4	-0.8%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	40.6	-	5,189.3	0.1%	5,148.6	-
Эргэлтийн бус хөрөнгө	106,607.0	3.1%	135,395.5	3.2%	28,788.5	27.0%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	138,840.7	4.1%	177,596.9	4.2%	38,756.2	27.9%
(Хуримтлагдсан элэгдэл)	-32,233.7	-0.9%	-42,201.5	-1.0%	-9,967.7	30.9%
Нийт хөрөнгийн дүн	3,400,793.2	100.0%	4,257,356.1	100.0%	856,562.9	25.2%


2023 оны III улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 8.6 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 12.8 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2018 оны мөн үед 1,202.0 тэрбум төгрөг байсан бол 2023 оны III улирлын байдлаар 3.5 дахин өсөж 4,257.4 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 96.0% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 350 ББСБ, 2.2% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 43 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.8 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 128 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	3,349.1	121	78.7%	23.2%	9.7	1	7.0	1	5.3	1
2.5-5.0 тэрбум	738.9	229	17.4%	44.0%	7.6	2	6.4	2	-	-
1.9-2.5 тэрбум	95.0	43	2.2%	8.3%	-	-	4.5	2	2.4	1
1.4-1.9 тэрбум	16.1	10	0.4%	1.9%	4.7	3	4.7	3	-	-
0.6-1.4 тэрбум	30.3	32	0.7%	6.1%	10.1	11	11.5	12	6.3	7
0.6 тэрбум хүртэлх	27.9	86	0.7%	16.5%	-	-	16.4	55	11.5	31
НИЙТ	4,257.4	521	100.0%	100.0%	32.1	17	50.5	75	25.5	40

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 2.2 их наяд төгрөг байгаа нь нийт активын 52.0 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 1.8 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 54.7 хувийг бүрдүүлж байна.

Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 127.3 тэрбум төгрөгөөр буюу 31.7 хувиар өсөж 529.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 21.5% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 48.4% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 30.0% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	529.3	242.4	351.5	177.8	25.3	515.3	14.0	43.7	53.4
Бэлэн мөнгө	114.0	8.9	109.0	5.0	19.9	105.8	8.3	0.1	3.7
Харилцах	256.3	119.4	159.5	96.8	4.8	251.2	5.2	41.3	44.6
Хадгаламж	158.9	114.0	83.0	75.9	0.5	158.4	0.5	2.4	5.1

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 31.0%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 2.8%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 79.0% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 2.6 дахин буюу 25.7 тэрбум төгрөгөөр өсөж, 2023 оны III улирлын байдлаар 29 ББСБ 41.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Богино хугацаат хөрөнгө оруулалтын 45.2% буюу 18.9 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас, 54.8% буюу 22.9 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 46.7% буюу 19.5 тэрбум төгрөг нь хувьцаа, 48.7% буюу 20.3 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 4.2% буюу 1.7 тэрбум төгрөг нь засгийн газрын үнэт цаасаарх, 0.4% буюу 165.9 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	41,678.2	39,285.2	6,372.2	35,306.0	1.0	40,788.7	889.5	18,906.3	16,089.4
Хувьцаа	19,484.9	18,092.9	3,732.1	15,752.8	1.0	18,686.4	798.5	13,560.6	11,407.0
Өрийн бичиг	20,353.7	19,363.7	2,628.1	17,725.6	-	20,263.7	90.0	5,212.2	4,703.8
Бусад	165.9	154.9	11.0	154.9	-	164.9	1.0	154.9	-
ЗГ-ын үнэт цаас	1,751.5	1,751.5	1,750.5	1.0	-	1,751.5	-	-	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	18,873.7	17,186.8	2,350.1	16,523.7	-	18,725.9	147.8	11,937.5	11,407.0
Арилжааны үнэт цаас	22,882.3	22,176.3	4,022.1	18,860.2	1.0	22,140.7	741.6	6,990.2	4,703.8

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 26 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 29 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Эдгээрийн 65.0 хувь нь буюу тусгай зөвшөөрөлтэй 17 ББСБ-ын холбогдох дансанд 38.8 тэрбум төгрөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт 2 ББСБ 1,751.5 сая төгрөгийн үнэт цаас бүртгэсэн байна.

Иймээс 12 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 46.2% буюу 4.8 тэрбум төгрөгөөр өсөж, 16 ББСБ 15.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. 2023 оны III улирлын байдлаар 5 ББСБ 567.8 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 147.4 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 15.4 тэрбум төгрөгийн цэвэр факторингийн тооцооны авлагын үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2022-III		2023-III		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь
	10,511.1	100.0%	15,370.7	100.0%	4,859.5	46.2%
Хэвийн	10,001.6	95.2%	14,802.8	96.3%	4,801.2	48.0%
Анхаарал хандуулах	167.9	1.6%	180.7	1.2%	12.8	7.6%
Чанаргүй	341.6	3.3%	387.2	2.5%	45.5	13.3%
Хэвийн бус	136.7	1.3%	285.0	1.9%	148.3	108.5%
Эргэлзээтэй	183.8	1.7%	70.0	0.5%	(113.8)	-61.9%
Муу	21.1	0.2%	32.2	0.2%	11.1	52.4%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	155.6	1.5%	147.5	1.0%	(8.1)	-5.2%

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч факторингийн тусгай зөвшөөрөлтэй 51 ББСБ-уудын 35 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа тул журамд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэлх арга хэмжээг авч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 2 банкны хувьд Хаан банк 2 харилцагчийн 8,744.0 сая төгрөгийн факторингийн авлагын үлдэгдэлд 30.6 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж 8,713.4 сая төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарсан бол Худалдаа хөгжлийн банк тайлан мэдээ ирүүлээгүй байна. Эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 8.7 тэрбум төгрөгийн, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын 44.0 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 1.9 тэрбум төгрөг буюу 9.5 хувиар өсөж 21.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	21,533.6	11,415.0	15,662.8	5,870.9	21,527.4	6.2	1,624.2	19,909.4	3,354.9
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	26,666.4	15,170.0	18,120.6	8,545.8	26,666.4	-	3,655.8	23,010.5	4,550.6
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	7,448.8	4,767.7	4,050.1	3,398.6	7,448.8	-	2,046.7	5,402.1	1,797.1
Өмчлөх бусад хөрөнгө	2,316.0	1,012.7	1,592.4	723.7	2,309.8	6.2	15.1	2,300.9	601.4

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.7% буюу 712.3 тэрбум төгрөгөөр өсөж 2023 оны III улирлын байдлаар 3,378.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 188.8 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 3,189.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	3,189.6	2,178.9	1,562.4	1,627.2	3,130.2	59.4	593.7	2,595.9	514.4
Нийт зээл	3,378.5	2,293.6	1,663.3	1,715.1	3,312.6	65.8	612.9	2,765.6	532.0
Хэвийн	3,007.0	2,059.6	1,466.4	1,540.6	2,949.7	57.2	564.8	2,442.2	487.8
Анхаарал хандуулах	119.6	84.9	58.9	60.7	117.7	1.9	20.7	98.8	18.2
Чанаргүй:	251.9	149.1	138.1	113.9	245.2	6.7	27.4	224.6	25.9
-Хэвийн бус	64.6	38.2	33.8	30.8	63.6	1.0	7.7	56.9	5.7
-Эргэлзээтэй	70.7	46.5	32.2	38.5	70.0	0.7	12.6	58.1	10.6
-Муу	116.7	64.4	72.1	44.5	111.6	5.1	7.1	109.5	9.6
(Зээлийн эрсдэлийн сан)	188.8	114.7	100.9	87.9	182.5	6.4	19.2	169.7	17.6
Нийт зээл (төгрөгийн)	3,284.9	2,210.3	1,646.6	1,638.3	3,219.1	65.8	576.2	2,708.8	495.2
Нийт зээл (валютын)	93.5	83.3	16.8	76.8	93.5	0.0	36.7	56.8	36.9
Зээлдэгчдийн тоо	1,461,198	931,626	200,175	1,261,023	1,433,807	27,391	193,213	1,267,985	98,977
- Иргэн	1,459,331	930,717	198,893	1,260,438	1,431,990	27,341	192,910	1,266,421	98,647
- Хуулийн этгээд	1,867	909	1,282	585	1,817	50	303	1,564	330

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Тайлант улиралд ББСБ-ууд 4.7 их наяд төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 4.0 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны III улирлын байдлаар 1,461,198 зээлдэгчийн 3.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/




Нийт зээлийн үлдэгдлийн 89.0 хувийг буюу 3.0 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.5 хувийг буюу 119.6 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.5 хувийг буюу 251.9 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.1, 0.4 пунктээр буурсан бол чанаргүй зээлийн хэмжээ 0.5 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 371.5 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 50.8%-д буюу 188.8 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2023 оны III улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 11.0% байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/




Олгосон зээлийн 90.4% буюу 2.9 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 9.6% буюу 309.3 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 90.8% буюу 2.6 их наяд төгрөг нь иргэдээс, 9.2% нь буюу 259.4 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	18,009.7	0.38%	18,641.2	0.5%	27,849.1	0.8%
2.	Уул уурхай, олборлолт	30,378.2	0.6%	27,490.7	0.7%	55,234.8	1.6%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	29,640.2	0.6%	26,078.8	0.6%	35,414.5	1.0%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	4,221.6	0.1%	3,161.3	0.1%	6,354.3	0.2%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1,826.3	0.0%	1,804.8	0.0%	2,030.9	0.1%
6.	Барилга	167,838.9	3.6%	135,407.5	3.4%	250,226.3	7.4%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	364,186.7	7.8%	309,519.8	7.7%	369,108.1	10.9%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	90,448.7	1.9%	82,022.7	2.0%	105,652.4	3.1%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	48,422.1	1.0%	38,045.2	0.9%	88,119.3	2.6%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	74,695.8	1.6%	49,358.3	1.2%	116,469.7	3.4%
11.	Мэдээлэл холбоо	6,052.5	0.1%	4,200.0	0.1%	11,355.3	0.3%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	93,538.2	2.0%	87,922.9	2.2%	54,616.1	1.6%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	26,136.9	0.6%	13,077.8	0.3%	32,127.2	1.0%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3,462.1	0.1%	8,184.4	0.2%	4,791.2	0.1%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	12,223.0	0.3%	13,294.1	0.3%	19,788.4	0.6%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,275.1	0.0%	1,396.3	0.0%	1,779.6	0.1%
17.	Боловсрол	14,128.8	0.3%	13,662.5	0.3%	18,854.2	0.6%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	9,224.6	0.2%	8,607.4	0.2%	11,920.4	0.4%
19.	Бусад	3,689,647.6	78.7%	3,178,492.6	79.1%	2,166,767.1	64.1%
<i>Иргэнд олгосон зээл</i>		<i>4,278,047.0</i>	<i>91.3%</i>	<i>3,675,406.9</i>	<i>91.4%</i>	<i>2,970,562.1</i>	<i>87.9%</i>
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		<i>407,310.1</i>	<i>8.7%</i>	<i>344,961.5</i>	<i>8.6%</i>	<i>407,897.0</i>	<i>12.1%</i>
НИЙТ		4,685,357.1	100.0%	4,020,368.4	100.0%	3,378,459.1	100.0%

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 78.7% буюу 3.7 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 7.8% буюу 364.2 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 79.1% буюу 3.2 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 7.7% буюу 309.5 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Тайлант улиралд олгосон 4.7 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 25.0 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 25.6 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 1.8 их наядын зээлийн 52.6 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 21.8 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 9.7 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	4,278.0	91.3%	3,675.4	91.4%	2,962.7	87.7%
Хэрэглээнд зориулсан зээл	3,085.0	65.8%	2,744.1	68.3%	1,778.7	52.6%
<i>Үүнээс: Автомашинд зориулсан зээл</i>	<i>606.3</i>	<i>12.9%</i>	<i>428.0</i>	<i>10.6%</i>	<i>736.9</i>	<i>21.8%</i>
Бизнес зориулсан зээл	579.8	12.4%	444.9	11.1%	697.1	20.6%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	117.4	2.5%	86.8	2.2%	177.4	5.3%
Бусад зээл	495.9	10.6%	399.6	9.9%	309.5	9.2%
Хуулийн этгээдэд олгосон зээл	407.3	8.7%	345.0	8.6%	407.9	12.1%
Бизнесийн зээл	323.1	6.9%	276.2	6.9%	328.9	9.7%
Автомашинны зээл	7.0	0.1%	6.4	0.2%	11.2	0.3%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	14.2	0.3%	9.7	0.2%	15.9	0.5%
Бусад зээл	62.9	1.3%	52.6	1.3%	51.8	1.5%
НИЙТ	4,685.4	100.0%	4,020.4	100.0%	3,378.5	100.0%

Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй финтек зээлийн үйлчилгээг 2023 оны III улирлын байдлаар 45 ББСБ үзүүлж байна. 4 ББСБ тоо мэдээгээ ирүүлээгүй байна.

Хүснэгт 19 Зээлийн ангилал

	Зээлийн дүн	Нийт дунд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дунд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	2,808,798,338.3	83.1%	322,770	22.1%	8,702.2
Цахим зээл	569,660,780.1	16.9%	1,138,428	77.9%	500.4
Нийт	3,378,459,118.5	100.0%	1,461,198	100.0%	2,312.1

2023 оны III улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1,138,428 зээлдэгчийн 569.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 77.9 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 16.9 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 500.4 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 17.4 дахин бага байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-ыг баталсан. Уг журам нь Хууль зүйн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 5807 дугаарт бүртгэгдэж, [Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийн 2022 оны 13 дугаарт](#) нийтлэгдсэнээр финтек зээл олгож байгаа ББСБ-уудын эрх зүйн орчин бүрдсэн. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад өмнө финтек зээлийн үйлчилгээ эрхэлж байсан ББСБ-ууд 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхийг үүрэг болгосон.

Ингэснээр 2023 оны III улирлын байдлаар 32 ББСБ журмын шаардлага хангаж, аппликэйшнээр бүртгүүлснийг [Санхүүгийн зохицуулах хорооны сайтад](#) байршуулсан байна.

Мөн бүртгэлтэй аппликэйшнээр зээл олгохоор 2 ББСБ мэдэгдсэн байна.

Хүснэгт 20 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд /2023 оны III улирал/

№	Финтек	Апп нэр	Бүртгүүлсэн огноо
1	Лэндмн	LendMN	2023.06.20-№7/2550
2	Соно финтек	Sono Mongolia	2023.03.03-№7/895
3	Инвескор	InvesCore	2023.08.25-№7/3350
4	Мобифинанс	Monpay	2023.06.20-№7/2540
5	Сэндли	Sendly	2023.07.04-№7/2821
6	Нөмөр кредит	Numur	2023.03.03-№7/890
7	Таван богд финанс	PayOn.mn	2023.07.04-№7/2826
8	Тус финтек	Tus fintech	2023.05.19-№7/2125
9	Инвескор хэтэвч	Pocket.mn	2023.05.08-№7/1871
10	Нэт капитал финанс корпораци	NetPay	2023.07.04-№7/2825
11	Бизнес-Инвест девелопмент	BiD	2023.08.25-№7/3353
12	Омни капитал	Moni	2023.07.05-№7/2869
13	ТОКИ	Toki	2023.06.20-№7/2549
14	Хатан суудал инвест	Zeely	2023.03.03-№7/894
15	Очир ундраа ОМЗ	Opay MN	2023.08.25-№7/3351
16	Ньюстар финанс	Nsf.mn	2023.06.20-№7/2552, 7/2553
17	Энт кредит инвестмент	EntCreditMN	2023.03.03-№7/891
18	Гэрэлфинанс	Gerel	2023.05.08-№7/1872
19	Говьфинанс	CashOne	2023.08.25-№7/3354
20	Цогзолфинанс	Pocket.mn	МЭДЭГДСЭН
21	Мөнгөнзоос кредит	Pocket.mn	МЭДЭГДСЭН
22	Грийн-Инвестмент	Gate.mn	2023.07.04-№7/2827
23	Зээл Эм Эн платформ	Zeel.mn	2023.07.04-№7/2828
24	Хас хаан	ХАСХААН	2023.06.20-№7/2551
25	Нанокapитал	Nano Capital	2023.07.04-№7/2824
26	Монголиа импакт финанс	Qmoni	2023.08.25-№7/3356
27	Жи Би Си Си	E-zeel	2023.03.03-№7/889
28	Онч-Энх	Ugloo	2023.03.30-№7/1297
29	Есөн финанс	MetaLend	2023.08.25-№7/3352
30	Инвеско фонд	IF.mn	2023.08.25-№7/3349
31	Ашид капитал	Simple, Simple Agent	
32	Ардкредит	Ard app	
33	Кэйш флов финанс	tugrug app	

34	Централ капитал	kmobi	
35	Жи Эс Би Капитал	GSB Prime, Mongolchat	
36	Грийн финтек	t finance, green fintech	
37	Фин экспресс	Finex	
38	Өсөх ундарга финанс	ufinance	
39	Начин заан финанс	Naizly	
40	Смарткапитал фонд	My Credit	
41	Нэмэх төгрөг	Most Money	
42	Гурван зуун жар финанс	Minu pay	2023.07.04-№7/2822
43	Есөн эрдэнэ финанс	Leasing.mn	2023.03.30-№7/1298
44	Франкфурт капитал	Nar app	2023.07.04-№7/2823
45	Гоулдман инвестмент групп	Goldpay	2023.08.25-№7/3355
НИЙТ			

/Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 6 ББСБ-ыг саарлаар тэмдэглэв/

Ногоон зээл

Тайлант хугацаанд 22 ББСБ 3,222 зээлдэгчид 52.3 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.7 хувийн хүүтэйгээр олгож, 26 ББСБ-ын 16,659 зээлдэгчээс 32.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны III улирлын байдлаар 30 ББСБ 9,878 зээлдэгчийн 135.8 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 4.0%-тай тэнцэж байна. Үүнээс 5-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээврийн хэрэгслийн дүнг хасаж тооцвол ногоон зээлийн үлдэгдэл нийт зээлийн үлдэгдлийн “0.3” хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 21 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 8 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	-	-
2. БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	254.0	8.0	64.4	4.0	289.6	6.0
3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	68.1	33.0	107.8	50.0	2,289.4	85.0
4. НОГООН БАРИЛГА	2,374.2	202.0	1,572.2	188.0	6,932.1	767.0
5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	-	-	49.9	1.0	0.1	1.0
6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	-	-	-	-	-	-
7. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	133.3	1.0	244.9	10.0	675.7	12.0
8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	54,455.2	2,978.0	30,303.9	16,406.0	125,620.1	9,007.0
Үүнээс:						
0-5 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	317.5	9.0	528.5	225.0	602.2	15.0
5-10 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	41,929.8	2,013.0	19,620.8	12,540.0	93,128.6	6,216.0
10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр	12,207.9	956.0	10,154.7	3,641.0	31,889.3	2,776.0
НИЙТ	57,284.8	3,222.0	32,343.2	16,659.0	135,807.1	9,878.0

Ногоон зээлийн үлдэгдлийн 92.5% буюу 125.6 тэрбум төгрөгийг карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Сэргээгдэх эрчим хүч, тогтвортой ус, хаягдлын хэрэглээний салбаруудад зээлийн үлдэгдэл байхгүй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 94.5% нь хэвийн, 3.7% нь анхаарал хандуулах, 1.8% нь чанаргүй ангилалд ангилагдсан ба Ногоон барилга болон Карбон бага ялгаруулдаг тээврийн салбарын зээлийн үлдэгдэл харгалзан 1.7%, 1.8% буюу хамгийн их хувь нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/



Бусад хөрөнгө

2023 оны III улирлын байдлаарх 319.4 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 49.5% буюу 158.0 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 26.9% буюу 86.0 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 23.6% буюу 75.5 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 22 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	319,434.7	193,064.7	195,655.7	123,779.1	8.6	313,593.2	5,841.6	38,847.6	33,519.5
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	157,960.7	88,561.6	100,007.5	57,953.2	-	155,678.8	2,281.9	17,046.7	20,189.5
-Үнэт цаасны	311.7	311.7	32.5	279.2	-	311.7	-	204.7	-
-Зээлийн	152,320.9	83,507.0	97,202.5	55,118.4	-	150,051.5	2,269.4	16,210.7	20,017.3
-Факторингийн	275.7	216.1	54.8	220.9	-	275.7	-	-	-
-Бусад	5,052.4	4,526.8	2,717.8	2,334.6	-	5,039.8	12.6	631.4	172.2
Авлага /цэврээр/	86,003.0	56,069.5	55,369.8	30,633.2	3.8	83,808.1	2,194.9	12,316.9	8,175.0
Нийт авлага	89,575.1	59,372.1	56,097.7	33,477.5	3.8	87,374.6	2,200.6	13,238.6	9,267.2
Хэвийн	82,404.6	54,904.3	52,503.6	29,900.9	0.3	80,218.2	2,186.4	12,249.9	8,102.8
Хугацаа хэтэрсэн	443.3	395.7	347.1	96.3	3.5	435.0	8.3	21.8	25.0
Чанаргүй:	6,727.2	4,072.1	3,246.9	3,480.3	-	6,721.4	5.9	966.9	1,139.5
-Хэвийн бус	778.6	776.9	1.8	776.8	-	777.9	0.6	10.5	10.0
-Эргэлзээтэй	908.7	119.8	788.9	119.8	-	908.7	-	76.9	81.9
-Муу	5,040.0	3,175.4	2,456.3	2,583.7	-	5,034.7	5.2	879.6	1,047.5
Нийт авлага (валютын)	70,368.9	40,169.3	37,863.2	32,505.7	3.8	68,168.3	2,200.6	13,238.6	9,267.2
Нийт авлага (төгрөгийн)	19,206.2	19,202.7	18,234.4	971.8	-	19,206.2	-	0.0	-
(Авлагын эрдэлийн сан)	3,572.1	3,302.6	727.8	2,844.3	-	3,566.4	5.7	921.7	1,092.2
Бусад актив	75,471.0	48,433.5	40,278.4	35,192.7	4.7	74,106.3	1,364.7	9,484.0	5,155.0

Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2023 оны III улирлын байдлаар 177.6 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 42.2 тэрбум төгрөгийн элэгдлийг хуримтлуулж бүртгэсэн байна. Ингэснээр тайлант хугацаанд 135.4 тэрбум төгрөгийн биет ба биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 23 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	135.4	70.6	65.2	70.2	0.2	132.6	2.8	11.0	11.5
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	177.6	93.4	85.8	91.8	0.33	173.7	3.9	16.6	16.6
Барилга байгууламж	59.1	38.9	24.0	35.1	0.05	58.0	1.1	2.8	2.2
Техник хэрэгсэл	63.2	24.9	40.1	23.1	0.05	61.3	1.9	4.0	5.2
Тавилга эд хогшил	21.8	12.9	11.5	10.3	0.19	21.4	0.5	4.6	5.3
Дуусаагүй барилга	7.9	1.8	5.9	2.0	0.04	7.8	0.1	0.02	-
Биет бус хөрөнгө	25.6	14.9	4.4	21.3	0.001	25.3	0.4	5.2	3.9
(Хуримтлагдсан элэгдэл)	42.2	22.9	20.6	21.6	0.13	41.1	1.1	5.6	5.1
Барилга байгууламжийн	9.4	7.4	3.0	6.4	0.002	9.3	0.2	1.7	0.4
Техник хэрэгслийн	24.2	10.2	13.0	11.2	0.03	23.5	0.7	2.0	2.5
Тавилга эд хогшлын	8.6	5.2	4.5	4.1	0.10	8.4	0.2	1.9	2.2

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар буюу 856.6 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 45.7 хувийг өр төлбөрийн өсөлт, 54.3 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:


Хүснэгт 24 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2022-III	Нийт дүнд	2023-III	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
Өр төлбөр	1,276,124.8	37.5%	1,667,723.1	39.2%	391,598.3	30.7%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	354,036.2	10.4%	519,346.5	12.2%	165,310.3	46.7%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	407,190.3	12.0%	470,565.3	11.1%	63,375.1	15.6%
Бусад эх үүсвэр	53,673.0	1.6%	54,017.7	1.3%	344.7	0.6%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	200,226.6	5.9%	263,511.1	6.2%	63,284.5	31.6%
Төслийн зээлийн санхүүжилт	19,352.7	0.6%	28,223.9	0.7%	8,871.2	45.8%
Бусад өр төлбөр	241,646.0	7.1%	332,058.6	7.8%	90,412.5	37.4%
Эздийн өмч	2,124,668.4	62.5%	2,589,633.0	60.8%	464,964.5	21.9%
Хувьцаат капитал	1,275,500.4	37.5%	1,453,045.0	34.1%	177,544.6	13.9%
Бусад өмч	60,994.4	1.8%	64,514.6	1.5%	3,520.2	5.8%
Сангууд	2,690.1	0.1%	1,282.8	0.0%	(1,407.3)	-52.3%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	714,938.5	21.0%	994,795.6	23.4%	279,857.0	39.1%
Хоёрдогч өглөг	70,545.0	2.1%	75,995.0	1.8%	5,450.0	7.7%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	3,400,793.2	100.0%	4,257,356.1	100.0%	856,562.9	25.2%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 46.7 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 45.8 хувиар ББСБ-аас гаргасан өрийн бичиг 31.6 хувиар өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 39.1 хувиар өсөж, бусад өмч 52.3 хувиар буурсан байна.


Сүүлийн 5 жилийн өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүдийг банкны салбартай харьцуулбал 2018 оны мөн үед өөрийн хөрөнгө банкны салбарын 30.1 хувьд хүрдэг байсан бол 2023 оны III улирлын байдлаар 49.1 хувьд хүрч байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2019 оны эхний хагас жилээс 2021 оны III улирал хүртэл банкны салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийг давдаг байсан бол 2023 оны III улиралд 87.5 хувьтай тэнцэж байна. Хуримтлагдсан ашгийн хувьд өмнөх оны мөн үед 37.9 хувьтай тэнцдэг байсан бол 2023 оны III улирлаар 0.5 пунктээр буурч 37.4 хувьтай тэнцэж байна.

Зураг 8 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг)



Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2023 оны III улирлын байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.8 дахин өсөж 2.6 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 6.2 дахин өсөж 1.7 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 9 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Итгэлцлийн үйлчилгээний өглөг

2023 оны III улирлын байдлаар өр төлбөрөөс хамгийн өндөр өсөлтийг итгэлцлийн үйлчилгээний өглөг үзүүлсэн байна. Өмнөх оны мөн үеэс 46.7% буюу 165.3 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 82 ББСБ-аас 74 ББСБ 7,681 итгэмжлэгчээс 519.3 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 10 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Улаанбаатар хотын 72 ББСБ 7,676 итгэмжлэгчээс 53.4 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 2 ББСБ 5 итгэмжлэгчээс 885.0 сая төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 25 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

Итгэлцлийн үйлчилгээний өглөг	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
-Төгрөгөөр	519.3	141.0	378.4	518.5	0.9	173.7	345.6	117.0
-Валютаар	68.6	9.9	58.6	68.6	-	29.1	39.4	111.7
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	82	58	24	79	3	5	77	7
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	74	49	23	72	2	5	70	7
Нийт итгэмжлэгчдийн тоо	7,681	2,215	5,466	7,676	5	3,088	4,593	344

Хамгийн өндөр дүнгээр буюу 99.4 тэрбум төгрөгийг 250 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол хамгийн олон буюу 2,023 итгэмжлэгчээс дунджаар 9.6 сая төгрөг нийт 19.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2023 оны III улирлын байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 15.6 хувиар өсөж, 113 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 519.3 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 26 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн 470.6	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл 373.2	Уламжлалт 197.0	Финтек 273.6	УБ 468.5	ХОН 2.1	ХК 155.2	ХХК 315.4	ГХО 149.2
Хугацаагаар:										
Богино хугацаат зээл	160.7	34.2%	120.1	94.9	65.8	160.2	0.6	34.2	126.5	35.2
Урт хугацаат зээл	309.8	65.8%	253.1	102.1	207.8	308.3	1.5	120.9	188.9	114.1
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	382.6	81.3%	303.5	161.3	221.2	380.5	2.1	114.3	268.3	92.2
Валютаар	88.0	18.7%	69.7	35.6	52.4	88.0	-	40.9	47.1	57.1
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	388.0	82.5%	308.1	162.2	225.9	385.9	2.1	118.9	269.1	96.4
Зээл /төгрөгөөр/	382.6	81.3%	303.5	161.3	221.2	380.5	2.1	114.3	268.3	92.2
Зээл /валютаар/	5.4	1.2%	4.6	0.8	4.6	5.4	-	4.6	0.8	4.2
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	82.6	17.5%	65.0	34.8	47.8	82.6	-	36.3	46.3	52.9

Бусад эх үүсвэр

2023 оны III улирлын байдлаар 18 ББСБ 54.0 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс нэр бүхий 5 ББСБ 12.2 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 3 ББСБ 8.1 сая төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 9 ББСБ 33.7 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй, нэр бүхий 1 ББСБ 1.7 сая төгрөгийн гадаад валютын арилжааны эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 27 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХК
Нийт	54,017.7	100.0%	41,700.8	17,478.1	36,539.6	54,017.7	332.0
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	12,185.6	22.6%	12,083.6	10,110.0	2,075.6	12,185.6	332.0
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	8,139.9	15.1%	7,970.7	169.2	7,970.7	8,139.9	-
Факторингийн үйлчилгээний өглөг	33,690.5	62.4%	21,644.8	7,197.2	26,493.3	33,690.5	-
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	1.7	0.0%	1.7	1.7	-	1.7	-

Өмнөх оны мөн үеэс мөнгөн гуйвуулга болон факторингийн үйлчилгээний өглөг харгалзан 1.0%, 14.9 хувиар тус тус буурсан бол факторингийн үйлчилгээний өглөг 24.2 хувиар тус тус буурсан байна. Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг, гадаад валют арилжааны эх үүсвэр тус тус 4.6, 14.9 дахин өссөн байна.

Зураг 11 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	2019-III	2020-III	2021-III	2022-III	2023-III
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр	-	55,000.0	-	-	-
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,858,778.7	7,951,349.2	11,620,642.7	12,312,637.6	12,185,601.3
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	4,059,710.0	230,756.4	215,738.7	1,758,815.8	8,139,918.6
Факторингийн үйлчилгээний өглөг	8,134,245.2	34,703,559.9	36,147,797.4	39,601,456.5	33,690,511.1
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	112.5	1,671.1
Нийт	15,052,733.9	42,940,665.5	47,984,178.8	53,673,022.5	54,017,702.1

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа болон гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг


2023 оны III улирлын байдлаар 40 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 1,480 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 263.5 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 28 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	263,511.1	246,248.3	41,453.7	222,057.4	262,419.1	1,092.0	77,288.5	186,222.6	53,260.0
Төгрөгөөр	251,073.3	234,021.8	41,242.4	209,830.9	249,981.3	1,092.0	77,288.5	173,784.8	53,260.0
Валютаар	12,437.8	12,226.5	211.3	12,226.5	12,437.8	-	-	12,437.8	-


Өрийн бичгийн үлдэгдэл 2018 оны мөн үеэс 11.3 дахин өсөж 263.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 12 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 5.4 хувь байсан бол 2023 оны III улирлын байдлаар 0.6 пунктээр буурч 4.7 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 29 Өрийн бичиг /валютаар/



Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 263 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ыг хүчингүй болгосонтой холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллана.

Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 13 ББСБ 28.2 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 30 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хугацаагаар	28,223.9		13,695.1	23,597.2	4,626.7	27,167.7	1,056.2	3,624.7	24,599.2	7,992.6
Богино хугацаат	7,226.9	25.6%	3,962.2	3,401.9	3,825.0	7,091.0	135.9	2,823.0	4,403.9	-
Урт хугацаат	20,997.0	74.4%	9,732.9	20,195.3	801.7	20,076.7	920.3	801.7	20,195.3	7,992.6
Төрлөөр										
Засгийн газрын	1,002.0	3.6%	1,002.0	-	1,002.0	1,002.0	-	-	1,002.0	-
Гадаадын	10,482.1	37.1%	9,617.2	6,857.4	3,624.7	10,482.1	-	3,624.7	6,857.4	5,992.6
Дотоодын	5,412.4	19.2%	3,075.9	5,412.4	-	4,356.3	1,056.2	-	5,412.4	2,000.0
Бусад	11,327.4	40.1%	-	11,327.4	-	11,327.4	-	-	11,327.4	-
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	23,820.2	84.4%	10,675.2	19,193.5	4,626.7	22,764.0	1,056.2	3,624.7	20,195.5	4,972.7
Валютаар	4,403.7	15.6%	3,019.9	4,403.7	-	4,403.7	-	-	4,403.7	3,019.9

Бусад өр төлбөр

2023 оны III улирлын байдлаар 477 ББСБ 280.4 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 15.4% буюу 43.3 тэрбум төгрөг нь 84 ББСБ-ын хуримтлуульж тооцсон хүүгийн өглөг, 82.8% буюу 232.2 тэрбум төгрөг нь 477 ББСБ-ын бусад пассивын үлдэгдэл байна.

Хүснэгт 31 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хуримтлуульж тооцсон хүүгийн өглөг	56,685.3	45,761.2	12,914.9	43,770.5	136.6	56,622.7	62.6	13,599.6	43,085.8	10,363.1
Ангиллаар										
Эзэлийн	22,519.0	12,159.7	7,956.4	14,562.6	136.6	22,472.3	46.8	2,983.8	19,535.2	2,898.9
Үнэт цаасны	5,092.9	4,872.5	43.5	5,049.4	-	5,092.9	-	1,755.6	3,337.3	1,334.5
Бусад	29,073.4	28,729.0	4,914.9	24,158.5	-	29,057.5	15.9	8,860.1	20,213.3	6,129.8
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	52,115.7	41,600.6	11,895.9	40,219.8	136.6	52,053.4	62.3	12,270.8	39,844.9	9,278.4
Валютаар	4,569.6	4,160.6	1,019.0	3,550.7	-	4,569.3	0.3	1,328.8	3,240.8	1,084.7
Бусад пассив	270,406.0	171,787.9	121,167.9	149,238.1	362.2	267,788.4	2,617.6	61,599.3	208,806.7	49,375.2

Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.9% буюу 177.5 тэрбум төгрөгөөр өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь нийт пассивын 34.1 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 32 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Энгийн хувьцаа	1,453,045.0	530,839.4	1,098,173.1	354,871.9	18,745.4	1,399,956.9	53,088.1	41,140.0	1,411,905.0	109,169.0
Энгийн хувьцаа	1,455,393.6	533,351.4	1,098,184.2	357,209.5	18,745.4	1,402,347.9	53,045.8	43,481.1	1,411,912.5	109,051.6
Давуу эрхтэй хувьцаа	199.3	36.0	199.3	-	-	157.0	42.3	-	199.3	121.0
Халаасны хувьцаа	2,548.0	2,548.0	210.4	2,337.5	-	2,548.0	-	2,341.1	206.8	3.6

Хувьцаат капиталын хэмжээ 2018 оны мөн үеэс 1.6 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт, үүнээс энгийн хувьцаа 1.6 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт, давуу эрхийн хувьцаа 5.3 дахин буурч 199.3 сая төгрөгт, халаасны хувьцаа 5.3 дахин өсөж 2.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2023 оны III улирлын байдлаар 521 ББСБ-ын 1.4 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 3 ББСБ-ын 199.3 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 3 ББСБ-ын 2.5 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 13 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 393 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 96.4% буюу 1.4 их наяд төгрөг байна. Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 128 ББСБ-ын 51.6 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.6 хувийг, ББСБ-уудын 24.6 хувийг бүрдүүлж байна.

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 290.2 тэрбум төгрөг байгаа нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 20.0 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 1.3 их наяд төгрөг байгаа нийт дүнгийн 75.5 хувийг бүрдүүлж байгаа зэргээс харахад томоохон ББСБ-ууд бусдаас хөрөнгө татан төвлөрүүлж үйл ажиллагаагаа явуулж байгаа тул хяналт шалгалтыг сайжруулах нь зүйтэй.

Хүснэгт 33 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	460.1	36	31.7%	6.9%	7.3	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	863.9	317	59.5%	60.8%	3.3	1	7.0	2	3.0	1
1.9-2.5 тэрбум	77.4	40	5.3%	7.7%	-	-	1.9	1	-	-
1.4-1.9 тэрбум	8.4	6	0.6%	1.2%	2.8	2	2.8	2	1.4	1
0.6-1.4 тэрбум	17.3	22	1.2%	4.2%	9.1	13	4.3	5	2.9	3
0.6 тэрбум хүртэлх	25.9	100	1.8%	19.2%	-	-	14.4	65	11.5	35
НИЙТ	1,453.0	521	100.0%	100.0%	22.4	17	30.5	75	18.7	40

Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өсөж 3.5 тэрбум төгрөгт, сангууд 52.3 хувиар буурч 1.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 34 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/


	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Бусад өмч	64,514.6	56,131.5	15,608.6	48,906.0	87.9	64,211.6	303.0	50,523.2	13,991.4	39,288.8
НТК	57,847.3	54,681.3	12,659.8	45,187.5	52.8	57,708.5	138.7	50,465.9	7,381.4	39,283.9
Дахин үнэлгээний нэмэгдэл	4,661.1	708.9	1,713.1	2,948.0	-	4,622.1	39.0	-	4,661.1	4.9
Хандивын капитал	2,006.2	741.3	1,235.6	770.6	35.0	1,881.0	125.2	57.3	1,948.9	-
Сангууд	1,282.8	105.7	1,249.5	33.3	-	447.4	835.4	2.3	1,280.6	64.3
Нөөцийн сан	694.9	51.0	711.4	(16.5)	-	121.6	573.3	(16.6)	711.5	62.3
Нийгмийн хөгжлийн сан	587.9	54.7	538.1	49.8	-	325.9	262.1	18.9	569.1	2.0

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 39.1% буюу 279.9 тэрбум төгрөгөөр өсөж 994.8 тэрбум төгрөгт хүрчээ.

Тайлант хугацаанд 449 ББСБ нийт 309.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 8 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 64 ББСБ 6.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 35 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/




Хоёрдогч өглөг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хоёрдогч өглөгийн хэмжээ 7.7 хувиар өсөж 5.4 тэрбум төгрөгт хүрчээ. 2023 оны III улирлын байдлаар 8 ББСБ 76.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

Ашигт ажиллагаа

2023 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 814.7 тэрбум төгрөгийн орлого олж, 512.3 тэрбум төгрөгийн зардал гаргаж 302.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 14 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 30.4% буюу 189.9 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 31.4% буюу 122.5 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 28.7% буюу 67.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 36 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/

ОРЛОГО	2022-III	2023-III	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	500,568,765.0	694,330,464.3	85.2%	193,761,699.3	38.7%
Хүүгийн бус орлого	110,049,297.7	102,696,398.8	12.6%	-7,352,898.8	-6.7%
-Санхүүгийн үйлчилгээний орлого	62,258,252.9	70,834,784.4	8.7%	8,576,531.5	13.8%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	57,896.3	21,089.4	0.0%	-36,806.8	-63.6%
- Мөнгөн гуйвуулгын орлого	1,898,902.2	3,507,976.5	0.4%	1,609,074.3	84.7%
- Картын үйлчилгээний орлого	-	909.5	-	909.5	-
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	44,570.9	-	-	-44,570.9	-100.0%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	46,715,328.6	49,681,867.0	6.1%	2,966,538.4	6.4%
- Бусад	13,541,227.3	17,622,942.1	2.2%	4,081,714.8	30.1%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	13,929,748.9	17,368,430.2	2.1%	3,438,681.3	24.7%
Ердийн бус орлого	261,619.2	276,139.8	0.03%	14,520.6	5.6%
НИЙТ ОРЛОГО	624,809,430.7	814,671,433.2	100.0%	189,862,002.4	30.4%
ЗАРДАЛ					
Хүүгийн зардал	68,630,821.1	98,250,105.5	19.2%	29,619,284.5	43.2%
Хүүгийн бус зардал	234,897,617.7	292,744,287.0	57.1%	57,846,669.3	24.6%
Болзошгүй эрсдэлийн зардал	51,903,841.4	69,237,547.6	13.5%	17,333,706.2	33.4%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	4,940,762.7	7,230,326.6	1.4%	2,289,564.0	46.3%
Орлогын албан татварын зардал	29,370,298.2	44,779,072.2	8.7%	15,408,774.0	52.5%
Ердийн бус зардал	18,324.5	22,610.3	-	4,285.8	23.4%
НИЙТ ЗАРЛАГА	389,761,665.6	512,263,949.4	100.0%	122,502,283.7	31.4%
АШИГ					
ЦЭВЭР АШИГ	235,047,765.1	302,407,483.8	100.0%	67,359,718.7	28.7%

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд хүүгийн орлого 38.7 хувиар буюу 193.8 тэрбум төгрөгөөр өсөж 694.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт 37 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хүүгийн орлого	694,330.5	497,166.7	299,386.6	394,943.9	48.8	681,391.3	12,939.2	120,118.3	98,181.1
Хүүгийн бус орлого	102,696.4	74,033.9	32,476.6	70,219.8	2,434.3	100,763.7	1,932.7	19,501.7	4,856.4
- Санхүүгийн үйлчилгээний орлого	70,834.8	50,783.9	17,413.3	53,421.5	0.3	68,984.5	1,850.3	16,825.7	3,259.4
Итгэлцлийн үйлчилгээний орлого	21.1	21.1	0.1	21.0	-	21.1	-	1.8	-
Мөнгөн гуйвуулгын орлого	3,508.0	3,100.5	2,961.5	546.4	-	3,507.1	0.9	546.4	0.0
Картын үйлчилгээний орлого	0.9	0.9	-	0.9	-	0.9	-	0.9	-
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-	-	-	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	49,681.9	42,266.5	8,673.6	41,008.3	-	48,134.2	1,547.7	15,766.1	2,851.8
Бусад	17,622.9	5,394.9	5,778.1	11,844.9	0.3	17,321.2	301.8	510.5	407.5
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	17,368.4	11,115.5	11,389.1	5,979.3	0.0	16,945.6	422.9	3,568.8	2,744.5
Ердийн бус орлого	276.1	62.0	232.2	43.9	-	231.1	45.0	-	-
НИЙТ ОРЛОГО	814,671.4	582,378.1	343,484.6	471,186.9	2,483.1	799,331.6	15,339.8	143,188.8	105,782.1
ЗАРДАЛ									
Хүүгийн зардал	98,250.1	86,014.1	34,654.5	63,595.6	-	97,779.2	470.9	21,240.4	15,691.0
Хүүгийн бус зардал	292,744.3	212,051.9	107,147.7	185,596.6	1,285.9	287,884.7	4,859.5	55,975.4	43,043.1
Болзошгүй эрсдэлийн зардал	69,237.5	49,024.4	25,100.3	44,137.2	-	67,797.3	1,440.3	13,962.7	8,740.2
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	7,230.3	3,671.3	4,242.1	2,988.2	0.1	7,111.6	118.7	831.2	1,490.3
Орлогын албан татварын зардал	44,779.1	33,729.9	17,449.0	27,330.1	47.1	44,366.2	412.9	10,216.2	6,964.4
Ердийн бус зардал	22.6	-	19.7	3.0	-	22.6	0.0	-	-
НИЙТ ЗАРЛАГА	512,263.9	384,491.7	188,613.3	323,650.7	1,333.0	504,961.6	7,302.3	102,225.9	75,929.0
АШИГ									
ЦЭВЭР ОРЛОГО	302,407.5	197,886.4	154,871.3	147,536.2	1,150.1	294,370.0	8,037.5	40,962.9	29,853.1


Орлогуудын хувьд ББСБ-уудын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын ногдол ашгийн орлого болон үнэт цаастай холбогдох орлогууд өмнөх оны мөн үетэй харьцуулахад өндөр өсөлттэй гарсан байна.

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь орлогын албан татварын зардал байна. 52.5 хувиар өсөж 15.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн үндсэн бус үйл ажиллагааны бусад зардал 66.7 хувь буюу 1.5 тэрбум төгрөгөөр өсжээ.

Гадаад валютын арилжааны мэдээ

Тайлант хугацаанд буюу 2023 оны III улиралд гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудаас ирүүлсэн тайлангаар 3,336.1 тэрбум төгрөгийн валют худалдан авсан нь банкны салбартай харьцуулахад 10.6 хувьтай тэнцэж байгаа бол 3,262.0 тэрбум төгрөгийн валют зарсан нь банкны салбартай харьцуулахад 10.7 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 38 Валютын арилжааны мэдээ улирал бүр /тэрбум төгрөгөөр/



Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2023 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 521 ББСБ-ын 86.0% буюу 449 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 14.0% нь буюу 73 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 59 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 9 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 4 ББСБ, 6 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 39 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /82 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /401 ББСБ/		ЗГВА /39 ББСБ/		Нийт /521 ББСБ/			
		√	X	√	X	√	X	√	X		
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	82	-	397	2	40	-	519	2		
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	82	-	397	2	40	-	519	2		
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	81	1	398	1	40	-	519	2		
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	78	4	393	6	40	-	511	10		
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	79	3	376	23	40	-	495	26		
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	82	-	387	12	XXX		509	12		
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	82	-	399	-			521	-		
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	82	-	396	3			518	3		
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	82	-	393	6			515	6		
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	399	-			521	-		
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	398	1			520	1		
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “П” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	82	-	399	-			521	-		
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	399	-			521	-		
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	82	-	399	-			521	-		
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	81	1	389	10			510	11		
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	81	1	XXX				520	1		
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	82	-	397	2			519	2		
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	81	1	383	16			40	-	504	17

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 26 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 17 ББСБ, болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны зохистой харьцаа алдагдсан 10 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 14 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 10 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

Дүгнэлт

2023 оны III улирлын байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 521 ББСБ-аас 501 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 20 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2023 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 28,369 хувьцаа эзэмшигчдийн 521 ББСБ, 453 салбар нэгж, 11 төлөөлөгчийн газар, 4,909 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 9 дүүрэгт давхардсан тоогоор 4.1 сая харилцагч, 1.5 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар өсөж, банкны салбарын 8.6%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 87.5%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.7 пунктээр өссөн дүн юм.

2023 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар буюу 856.6 тэрбум төгрөгөөр өсөж 4.3 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 83.2 хувийг нийт зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 54.3 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн 2 жилийн хугацаанд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /153 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.7% буюу 712.3 тэрбум төгрөгөөр өсөж 2023 оны III улирлын байдлаар 3,378.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 188.8 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 3,189.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Тайлант улиралд ББСБ-ууд 4.7 их наяд төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 4.0 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны III улирлын байдлаар 1,461,198 зээлдэгчийн 3.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 89.0 хувийг буюу 3.0 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.5 хувийг буюу 119.6 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.5 хувийг буюу 251.9 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.1, 0.4 пунктээр буурсан бол чанаргүй зээлийн хэмжээ 0.5 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 371.5 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 50.8%-д буюу 188.8 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2023 оны III улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 11.0% байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар буюу 763.2 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 36.2 хувийг өр төлбөрийн өсөлт, 63.8 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өглөг 46.7 хувиар, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 15.6 хувиар, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 31.6 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 45.8 хувиар тус тус өссөн байгаа нь ББСБ-уудын хувьд бусдаас өртөг бүхий эх үүсвэрийг татан төвлөрүүлж байгааг харуулж байна.

Ашигт ажиллагаа

2023 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 814.7 тэрбум төгрөгийн орлого олж, 512.3 тэрбум төгрөгийн зардал гаргаж 302.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн

үеэс орлогын хэмжээ 30.4% буюу 189.9 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 31.4% буюу 122.5 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 28.7% буюу 67.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2023 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 522 ББСБ-ын 86.0% буюу 449 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна. Нийт ББСБ-уудын 14.0% нь буюу 73 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 26 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 17 ББСБ, болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны зохистой харьцаа алдагдсан 10 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 14 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 10 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР